

БАТЛАВ:  
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ  
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:  
“ТҮМЭН АЙЛ КӨҮЛ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Н.ОРГИЛ

“ТҮМЭН АЙЛ КӨҮЛ” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМЫН НУТАГТ  
ОРШИХ БАЯНШАНД НЭРТЭЙ УУРХАЙН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ  
ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ  
АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-022979/  
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР 8482993/

ХЯНАСАН:

БОЛОВСРУУЛСАН:  
“ТҮМЭН АЙЛ КӨҮЛ” ХХК-ИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Ж.МАЙРА  
А.ТЭМҮҮЛЭН

## 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### Төсөл хэрэгжүүлэгч

“Түмэн айл көүл” ХХК нь 9011861164 тоот улсын бүртгэлийн дугаартай .

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 1-р хороо Олимпын гудамж 39-р байр ЖИ центр 10 давхар

**Төсөл хэрэгжүүлэгчийн тусгай зөвшөөрөл:** Баян шанд нэртэй MV-022979 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Түмэн айл инвест” ХХК-ийн эзэмшлийн Довцог худаг нэртэй MV-021530 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг бусдад хэсэгчлэн шилжүүлэхтэй холбоотойгоор нөөцийн хуваагдлыг харилцан тохиролцсон тухай АКТ ыг АМГТГ, “Түмэн айл инвест”, “Түмэн айл Көүл” ХХК нар харилцан тохиролцож 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр баталгаажуулан авсан. Тусгай зөвшөөрөл нь 2050 оны 01 дүгээр сарын 21-ний өдийн хугацаагаар олгогдсон байна.

Баян шандын нүүрсний орд нь засаг захиргааны нэгжийн хувиар Дорноговь аймгийн Мандах сумын нутагт харьяалагдах ба сумын төвөөс урагш 30 км, Сайншанд хотоос баруун урагш тийш 200 км, Улаанбаатар хотоос зүүн урагшаа 484 км зайд, Монгол Хятадын хилийн Ханги боомтоос баруун хойш 235 км-г оршдог.

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дорноговь аймаг 114.5 мянган км<sup>2</sup> нутагтай Монгол орны зүүн өмнөд хэсэгт оршдог. Дорноговь аймаг нь говийн бүсэд багтах бөгөөд Оцол сансар, Их бага дулаан, Хутаг уул, Аргал, Аргалант, Баян, Арван найман богд зэрэг уул толгод эзэлдэг, хамгийн нам дор газар Баянгийн говь далайн түвшнээс дээш 703 метр өндөрт оршино. Нутгийн өмнөд хэсгээр бага зэрэг элстэй. Зам харилцааны хувьд Улаанбаатараас Говь-Сүмбэр-Сайншанд хот хүртэл хатуу хучилттай замаар, Говьсүмбэр-Мандах сум, Сайншанд-Мандах сумаар нэвтрэлт сайтай шороон замаар явж хүрнэ.

Тус аймгийн нутгаар Улаанбаатар-Сайншанд-Замын-Үүдийг холбосон 726 км, Сайншанд Зүүнбаян өртөө хүртэл 47 км, нийт 770 гаруй км үргэлжилсэн төмөр замаар ачаа, зорчигч тээн аймгийн төвийг улсын нийслэлтэй болон өмнөд хөрштэй холбодог юм. Энэ замын дагуу Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд зэрэг төмөр замын өртөө суурин бий. Бусад сумдад хүн, шуудан, ачаа тээврийг авто машинаар гүйцэтгэж байна. Дорноговь аймгийн бүх сумд цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон бөгөөд үйл ажиллагааг Чойрын ЦТСС, УБТЗ-ын ЭХУХ-ийн 2-р анги, Дорноговь ЦССалбарууд тус тус хариуцан ажиллаж байна. Дорноговь аймаг ашигт малтмалаар баялаг бөгөөд хайлуур жонш, гөлтгөнө, чулуун нүүрс, газрын тос, алт, зэс никел, төмөр, марганец, хром, гянт болд, цагаан тугалганы зэрэг 38 төрлийн ашигт малтмалын 73 орд, 440 гаруй илэрцүүд тогтоогдсон бөгөөд уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжих нөхцөл бүрдэж байна.

### Мандах сумын танилцуулга

Мандах нь Дорноговь аймгийн сум бөгөөд аймгаас 170км, нийслэл Улаанбаатараас 454 км зайд оршино. Мандах сум нь Төхөм, Сэрвэн Баянхошуу, Өехий, Алхан тээг, Баянхошуу гэсэн 5 багтай. Мандах сум нь Түшээт хан аймгийн Ачит гүний хошууны залгамж үе нь билээ. Түшээ хан аймгийн Ачит гүний хошуу нь 1967 оноос түүхээ эхэлж Ардын хувьсгалын үе буюу 1921 он хүртэл үе залгамжилсан 12 Засаг ноёны удирдлагыг дамжсан юм. 1924 оны 8 дугаар сард Ачит гүний хошууг Түшээт хан аймгийн Ёст гүний хошуутай нэгтгэн ХОЁР ӨЛЗИЙТ уулын хошуу гэж нэрийдсэн бөгөөд уг хошууг Богд Мандах, Манлай, Баясгалант, Өндөршил гэсэн 4-н суманд хувааснаар Мандах сум байгуулагдсан. Ийнхүү 1924 оны 08-р сарын 01-нд Мандах сум Хийморьт хэмээх газар анхных тулганы чулууг тулж, төрийн сүлд тугаа залж, тамга түшсэн түүхтэй. Анхны туг сүлдээ залсан Хийморьтоос Гүн шавагтай, Номт, Дов, Замын дэл зэрэг газарт төвлөрч явсаар 1939 онд өөдлөн дэвжихийн бэлэгдэл бодож Дөл хад буюу одоогийн Төхөмд төвлөрчээ.

Тухайн үед тус сум нь 4 баг 200 гаруй өрх, 500 гаруй хүн амтай, 30-аад мянган малтай байжээ. Алхан тээг, Баянхошуу, Сэрвэн Баянхошуу, Өехий, Төхөм гэсэн 5-н багт 1566 хүн амьдардаг. Тус сум Дорноговь аймгийн баруун зах, Өмнөговь аймгийн Манлай, Ханбогд, Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил өөрийн аймгийн Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумтай хил залгаа оршдог. Нийслэл Улаанбаатар хотоос 454 км, аймгийн төвийнхөө баруун хэсэгт 170 км-т байрладаг.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх (Avoidance):** Нөлөөллөөс зайлсхийх нь нөлөөллийг бууруулах дарааллын хамгийн эхний бөгөөд чухал алхам болно. Төсөл хэрэгжих талбайн биологийн төрөл зүйл, амьдрах орчны судалгаа шинжилгээний болон төслийн технологийн мэдээллүүдийг ашиглан төслийн төлөвлөлтийн шатанд болзошгүй нөлөөллөөс зайлсхийх арга замуудыг тодорхойлдог. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх зарим сөрөг үр дагавраас зайлсхийснээр сөрөг нөлөөллийн цар хүрээг тэлэхгүй байх, болзошгүй сөрөг нөлөөллөөс бүрэн зайлсхийх боломжтойгоос энэ нь удирдлага, менежментийн оновчтой шийдлээр хангагдана. Зайлсхийх арга хэмжээг хэрэгжүүлэгчүүдээс сөрөг нөлөө үүсэх, түүнээс шалтгаалж нөлөөллийн цар хүрээ тэлснээр орон нутгийн иргэдээс гомдол гарах, олон нийттэй маргаантай харилцаанд орох, улмаар байгаль орчинд хохирол учруулах тохиолдол гардгийг төсөл хэрэгжүүлэгчид сануулж, төслийн үйл ажиллагаанаас үүсэх зарим сөрөг нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

**Гол сөрөг нөлөөллийг бууруулах (Minimization):** Энэ шатанд зайлсхийх боломжгүй нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ хамаарах бөгөөд энэ төслийн хувьд зайлшгүй үүсээд орчны шинжилгээ хийж байнгын хяналт, анхаарлын төвд байгаа сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүд хамаарна. Төсөл хэрэгжилтийн дунд шатанд хийгдэж байгаа энэхүү үнэлгээний хүрээнд сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүд нь төслийн өмнөх үеийн үйл ажиллагаанд нэвтэрч, хэрэгжүүлж ирсэн арга хэмжээнүүдтэй аль болох давхцуулахгүй байхыг хичээх тул өмнөх үнэлгээгээр өгсөн зөвлөмжүүдийг цаашид үргэлжлүүлэн мөрдөх шаардлага байгааг төсөл хэрэгжүүлэгч анхаарах хэрэгтэй. Сөрөг нөлөөг бууруулах зөвлөмжүүд нь ихэвчлэн техникийн болон технологийн нэмэлт арга хэмжээгээр олборлох үйл ажиллагааны дундуур хэрэгжих шаардлагатай байдаг тул байгаль орчны хамгааллын зардлыг нэмэгдүүлэх, зарим тохиолдолд үйл ажиллагааны үр ашиггүй зардлыг нэмэгдүүлэх талтай юм.

### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

#### Гол зорилтууд:

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших “Түмэн айл көүл” ХХК-ийн Баяншанд нүүрсний ордыг ашиглах төслийн ашиглалтын 5 жилийн БОМТ-г Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, баримтлан боловсруулсан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн XII сарын 10-ны дотор тухайн жилийн БОМТ- ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль

орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

*Хүснэгт 1. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын задаргаа*

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2026 он/сая.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10,700.00
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	82,331.50
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	15,000.00
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	1,500,000
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5,000.00
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	8,000.00
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	10,000.00
9	Удирдлага зохион байгуулалт	-
10	Орон нугийн шаардлага болон оршин суугчдад тайлагнах	
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>132,531.50</b>

## 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

### Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлтийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Хаягдал нүүрс болон бүтээгдэхүүн тээвэрлэх замыг тогтмол усалж байх Үйлдвэрийн орчинд тоосжилт үүсгэхгүй байх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх	Уурхайн дотно, гадна зам	удаа	1900,000	1	1,900,000	2026 он	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Дизель хөдөлгүүрт MNS 5014:2009
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Газрын доорх усны мониторингийн цэгийг засварлах	Гүний худаг	удаа	Гэрээний дүнгээр			2026 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 327-д дугаар тогтоолын хавсралт Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ
3		Тоолуурын заалтын дагуу ус ашигласны төлбөрийг төлөх, холбогдох ус ашиглах дүгнэлт, гэрээг байгуулах	Уурхайн ус ашиглалт	удаа	300,000	1	300,000	2026 он	
4		Дэлхийн усны өдрийг тохиолдуулан сав газрын захиргаанаас зохион байгуулж буй ажилд дэмжлэг үзүүлэн хамтран оролцох	Галба-Өөш-Долоодын сав газрын захиргаа	удаа	3000,000	1	3,000,000	2026 он	
5	Газрын гадрага болон хөрсөн бүрхэвч	Шатах тослох материалын бий болж болзошгүй газруудад хамгаалалтын суурийг сайн тавьж өгөх	Аюултай хог хаягдлын цэг	удаа	2000,000	1	2,000,000	2026 он	”MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
6		Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, хог хаягдлын цэгийг хатуу хучилттай болгох, хяналт тавих, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээ авч ажиллах	Засварын төв	удаа	1,800,000	1	1,800,000	2026 он	
7	Ургамлан нөмрөг	Хөндөгдөж буй талбайн ургамлын бүртгэл хөтлөх	Хөндөгдөж буй талбай	удаа	Үйл ажиллагааны зардлаар			2026 он	-

8	Амьтны аймаг	Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар сануулга өгөх, ан амьтны талаарх мэдээллийг нийт ажилтан, гэрээтүүдэд мэдээлж, хамгааллын талаар сургалт, сурталчилгаа хийх, үйлдвэрийн болон уурхайн бүсэд зэрлэг амьтан нэвтэрсэн тохиолдолд хариуцах албанд хэрхэн мэдэгдэх талаарх мэдээллээр хангах.			1,700,000	1	1,700,000	2026 он	Амьтны тухай хууль
9		Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар сануулга өгөх, ан амьтны талаарх мэдээллийг нийт ажилтан, гэрээтүүдэд мэдээлж, хамгааллын талаар сургалт, сурталчилгаа хийх, үйлдвэрийн болон уурхайн бүсэд зэрлэг амьтан нэвтэрсэн тохиолдолд хариуцах албанд хэрхэн мэдэгдэх талаарх мэдээллээр хангах.							
Нийт зардал мян. төг							10,700,000		

### 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

#### 0Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Техникийн нөхөн сэргээлт	2026 онд уул техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй						
2	Биологийн нөхөн сэргээлт	Нөлөөлөлт өртөх талбайн шимт хөрс хуулалт, тээвэрлэлт хадгалалт хамгаалалтыг хэрэгжүүлэх, бүртгэл хөтлөх	М.куб		77,331,500		2026 он тухай бүр	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт, 2012 оны Ойн тухай хууль,
3		Кемпийн гадна талбайд мод тариалах	Ширхэг	200	25,000	5,000,000	2026 оны хавар, намар	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Нийт зардал мян. төг						82,331,500		

### 7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох

**Тусгай зөвшөөрлийн талбайн нөлөөллийн бүсийн айл өрх.** Тусгай зөвшөөрлийн талбайд давхцал бүхий айл байхгүй тусгай зөвшөөрлийн талбайн гадна 2.3-6.1квт 5 айлын өвөлжөө хаваржаа байна.

Тийм учраас нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй болно.

### 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

- Лицензтэй талбайгаас олборлолтын үед түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Археологийн дурсгал, Палеонтологийн дурсгал	Дорноговь аймгийн Музейн сургалт судалгааны төвөөс соёлын биет болон биет бус өвийн тухай сургалт мэдээлэл авах.	Уурхайн ажилчид	1	1,500,000	1,500,000	Жилд 1	Соёлын өвийг хамгаалах тухай хууль 2014 он
Нийт зардал мян. төг					1,500,000			

### 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө:

*Хүснэгт 3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ*

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Баяншанд уурхайн “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө	Зэрлэг ан амьтадад чиглэсэн биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн бүхий л арга хэмжээ	1	15,000.000		2026	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага 2018
2		Аймгийн байгаль орчны газраас санал авч хамтран ажиллах	Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ	1			2026	
3	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд	Аймгийн байгаль орчны газар, сумын Засаг даргын тамгын газартай зөвлөлдөн мод тариалах	Ширхэг	1000	Гэрээний дүнгээр	2026 оны хавар, намар		
Нийт зардал мян. төг						15,000.000		

## 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгалийн аюул гамшиг								
1	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах		1	250.000	250.000	2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003-(сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17)
Галын аюул								
2	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах;	Галын аюул эрсдэл	1	3,550,000	3,550,000	2026 он	MNS 5390:2004, ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага Галын аюулгүй байдлын тухай хууль, /шинэчилсэн найруулга/ Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS4244-94 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага
Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар								
3	Төслийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах. Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах	Төслийн талбайд	1	100.000	100.000	2026 он	MNS 4968:200“ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” MNS 4995:2000, “ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”

4	Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах	Төслийн талбайд	1	350.000	350.000	2026 он	MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”
5	Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах, Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн эм тариаг бэлэн байлгах	2	750.000				
<b>Нийт зардал мян. төг</b>					<b>5,000,000</b>		

### 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

#### Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, ялгах, хог хаягдлыг дахин ашиглах	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалтын хогийн савнуудыг шаардлагатай газруудад байрлуулан эх үүсвэр дээр ангилан ялгах	Энгийн хог хаягдлаас үүсэх нөлөөллийн бүс	удаа	400.000	1	400.000	2026 он	Хог хаягдлын тухай хууль; БОАЖ-ын сайдын А/433 тушаал
2		Хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.		удаа	Үйл ажиллагааны зардлаар			Улирал бүр	БОАЖ-ын сайдын 2017 оны А/349 тушаал
3	Хог хаягдлаас ялгарах үнэр, амархан муудаж ялзрах бусад хүнсний хаягдал зэргээс халдварт өвчин тархах	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Хог хаягдлын цэг	Удаа	2.600.000	1	2.600.000	2026 он	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; БОАЖ-ын сайдын 2017 оны А/368 тушаал
4	Аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Хэрэглэсэн батарей, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах	Аюултай хог хаягдал	Удаа	5,000,000			2026 он	Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол

5	Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан, хаягдал тос боловсруулах, тээвэрлэх байгууллагатай гэрээ байгуулан шилжүүлэх	Аюултай хог хаягдал	Удаа			хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, усгах болон бүртгэх, тайлагнах журам
Нийт зардал мян. төг					8,000,000	

## 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

### Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Агаар /нийт тоос, хүхэр, дуу чимээ	Нүүрсний задгай агуулах, кемп, уурхай, дотоод болон гадаад тээврийн зам	Улиралд 1	4	1,090,000	4,360,000		Агаарын чанар MNS 4585:2016
2	Ус / химийн болон бактериологийн үзүүлэлтээр шинжлүүлэх/	Ундны усны гүний 2 худаг, Малчны 3 худаг, Уурхайн шүүрлийн усны дээж	Улиралд 1	4	80,000*5*2=800,000	3,200,000		MNS 4943:2015
3		Хаягдал уснаас дээж авах		4	80,000*2=160,000	640,000		Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
4	Хөрс /хүнд метал, хими, механик бүрэлдэхүүн,	Хөрсний дээжлэлттэй 9 цэгүүдэд	Улиралд 1	4	50,000*9=450,000	1,800,000		Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга, MNS 5850:2008
5	Ургамал	Ургамлын 10 цэг	Жилд 1	1	Үйл ажиллагааны зардлаар			Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч
6	Амьтан	амьтны мониторинг судалгааг үржлийн орчны 5000 м <sup>2</sup> талбайд/	Жилд 1	1	Үйл ажиллагааны зардлаар			бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт зардал мян. төг						10,000,000		

### 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

#### Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, сая төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь 2026 он				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			1-3 сар	4-6 сар	7-9 сар	10-12 сар		
1	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох	+	+	+	+	Үйл ажиллагааны менежер	
2	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	+	+	+	+	Үйл ажиллагааны менежер	
3	2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн зардлын 50%-тай тэнцэх барьцаа хөрөнгийг тусгай дансанд байршуулах	Уурхайн дотоод төлөвлөлтөөр		+			БО-ны мэргэжилтэн	
4	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	+	+	+	+	БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	
Нийт зардал мян. төг			-					

### 14. Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх

#### Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тайлан хүргүүлж тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүрийн 11 сард	-	БО-ны мэргэжилтэн	БОУАӨЯ
2	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, сумын Засаг дарга,	Танилцуулж, тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	-	БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Засаг даргын тамгын газар
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Тайлагнах	Үйл ажиллагааны явцад түүхт дурсгалт зүйлс болон соёлын олдвор олдсон тохиолдолд ямар арга хэмжээ авсан талаар	Тухай бүрд	-	БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Засаг даргын тамгын газарт
Нийт зардал мян. төг					-		